ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ**

ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН

# МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

2022 оны 04 дугаар сарын 29 өдөр

Дугаар 89/2022

Улаанбаатар-16100
Утас: 70001150
Факс: 70007636

| | |
|---|---|
| **Объектын нэр:** | Баян-Өлгий аймгийн Бугат сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл шинэчлэлт болон шинээр хийгдэх авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл |
| **Объектын байршил:** | Баян-Өлгий аймаг, Бугат сум |
| **Хүчин чадал:** | 5.818 км |
| **Захиалагч:** | Баян-Өлгий аймгийн Бугат сумын Засаг даргын Тамгын газар |
| **Санхүүжилтийн эх үүсвэр:** | Улсын төсөв |
| **Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр,** | “Кадсүрвэй” ХХК |
| **Регистрийн дугаар:** | 5102472 |
| **Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:** | 2022.10.11 |

**<u>Зураг төсөл боловсруулах үндэслэл:</u>**

| | |
|---|---|
| Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх, олгосон захирамж, дугаар огноо: | - |
| Зураг төсөл боловсруулах даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо: | Баян-Өлгий аймгийн Бугат сумын Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр баталсан авто зам, замын байгууламж, нийтийн тээврийн буудлын зураг төсөл боловсруулах ажлын даалгавар, № ЗД/БТ/2021/01 |
| Зураг төсөл боловсруулах гэрээ, баталсан албан тушаалтан, дугаар, огноо | Баян-Өлгий аймгийн Бугат сумын Засаг даргын Тамгын газар болон “Кадсүрвэй” ХХК-ийн хооронд 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан авто замын зураг төсөл боловсруулах ажлын гэрээ, № 21/05<br>Зураг төслийн гэрээний үнэ: 75 000 000 төгрөг |

**<u>Техникийн нөхцөл:</u>**

| Техникийн нөхцөл | Олгосон байгууллага | Дугаар, огноо | Хүчинтэй байх хугацаа |
|---|---|---|---|
| | | | |

**<u>Зөвшилцсөн байгууллага:</u>**

| | |
|---|---|
| Бугат сумын Засаг дарга | А.Жамбал |

**<u>Зураг төслийн бүрэлдэхүүн:</u>**

| Зургийн бүрдэл: | Зураг төслийг гүйцэтгэсэн байгууллагын нэр: | Шалгасан экспертийн нэр: |
|---|---|---|
| Авто замын зураг төсөл | “Кадсүрвэй” ХХК | У.Пүрэвжав |
| Тайлбар бичиг | | |
| Техникийн шаардлага | | |
| Авто замын төсөв | | Л.Баасанбат |
| Геодезийн тайлан | | - |
| Инженер-геологийн тайлан /Барилгын хөгжлийн төвөөр 2021.11.25-ны өдөр магадлал хийсэн байна./ | “Инжгеотех” ХХК<br>Архив № 11 2021 078 | Ю.Энхсайхан |

**Ерөнхий дүгнэлт:**

| | |
|---|---|
| Авто зам, замын байгууламжийн чигийн сонголт болон техник-эдийн засгийн үзүүлэлтүүд, зураг төслийн үндсэн төлөвлөлт, шийдэл, хучилтын бүтээцийн талаарх дүгнэлт | **Авто зам, замын байгууламжийн төлөвлөлт, хүчин чадал:**<br>**Авто замын ангилал:** Хуримтлуулагч зам,<br><u>Төрөл 1:</u><br>Зорчих хэсгийн өргөн 7.0м, явган хүний замын өргөн 2x1.5м, хөвөөний өргөн 2x0.5м,<br><u>Төрөл 2:</u> |

| | |
|---|---|
| | Зорчих хэсгийн өргөн 7.0м, хөвөөний өргөн 2х2.0м,<br><u>Төрөл 3:</u><br>Зорчих хэсгийн өргөн 6.0м, явган хүний замын өргөн 2х1.5м, хөвөөний өргөн 2х0.5м байхаар төлөвлөсөн байна.<br>**Авто замын хучилтын хийц:**<br><u>Төрөл 1:</u><br>Асфальтбетон хучилт өнгө 30мм<br>Асфальтбетон хучилт суурь 40мм<br>Хуучин асфальтбетон хучилтыг дахин боловсруулж сууринд ашиглах /5% цемент/ 200мм<br>Хуучин далан<br><u>Төрөл 2:</u><br>Асфальтбетон хучилт өнгө 30мм<br>Асфальтбетон хучилт суурь 40мм<br>Буталсан чулуун суурь 200мм<br>Хөлдөлтөөс хамгаалах үе 300мм<br>Далан<br><u>Төрөл 3:</u><br>Нягт асфальтбетон хучилт 30мм<br>Суурь асфальбетон 40мм<br>4% цементээр бэхжүүлсэн суурь 200мм<br>**Явган хүний замын хучилтын хийц:**<br><u>Төрөл 1:</u><br>Өнгөт хавтан /Зигзаг хавтан/<br>Хайрган хөвөө<br>Хөлдөлтөөс хамгаалах үе 300мм<br>Далан<br><u>Төрөл 2:</u><br>Өнгөт хавтан /Зигзаг хавтан/<br>Элс хайрган суурь 100мм<br>Далан<br>**Төмөрбетон хоолой:**<br>ПК41+000, ПК42+80 цэг дээр ф1.0м хэмжээтэй төмөрбетон дугуй хоолой төлөвлөсөн байна. |
| Боловсруулсан зураг төслийн сонгосон шийдэл, магадлалын явцад хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс шалтгаалах үр дүнгийн талаарх тодорхой санал, дүгнэлт: | Орон тооны бус экспертийн дүгнэлтийн дагуу зураг төсөлд холбогдох засвар, өөрчлөлтүүдийг оруулж дахин хянуулан баталгаажуулсан байна. Үүнд:<br><u>Зураг төсөлд:</u><br>Авто замын зураг төсөлд /2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн дүгнэлт/<br><u>Төсөвт</u><br>Авто замын төсөвт /2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн дүгнэлт/<br>Дээрх дүгнэлтүүд нь магадлалын ерөнхий дүгнэлтийн хавсралт болно. |
| Зураг төслийн талаар явуулж байгаа төрийн нэгдсэн бодлого, хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийг үндэслэн боловсруулсан төслийн сонгосон шийдэл, төслийг хэрэгжүүлснээр гарах үр дүнгийн талаарх тодорхой санал, дүгнэлт | Зураг төслийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах норм, дүрмүүдийг баримтлан боловсруулсан байна. Үүнд:<br>-ЗЗБНбД 22-004 -2016 “Авто зам төсөллөх”<br>-БНбД 30-01-04 “Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм”<br>-БНбД 32-01-04 “Хот суурины гудамж, зам төлөвлөлт”<br>-БНбД 32-02-12 “Авто замын гүүр ба хоолой төсөллөх”<br>-БНбД 81-25-07 “Авто замын барилгын төсвийн жишиг норм”<br>-БНбД 81-28-07 “Төмөрбетон гүүр, хоолойн барилгын төсвийн жишиг норм”<br>-ЗЗБНбД 81-013-2019 “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм” |
| Эдийн засгийн үр ашиг, хөдөлгөөний аюулгүй байдал, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, төсөвт өртгийн тооцооны талаарх дүгнэлт | Төсвийг орон тооны бус экспертүүд дараах байдлаар хянаж баталгаажуулсан байна. Үүнд:<br>Авто замын барилгын ажлын төсөв **5 685 322 926** төгрөг<br>Төсвийн нийт тооцоо, иж бүрдлийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа үнэ бүрдлийн норм, нормативын дагуу тооцсон болохыг хянаж, дүгнэв. |

**“Авто замын тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4, 19.5 дахь заалтад заасны дагуу Авто зам, замын байгууламжийн зураг төслийн алдааг зураг төсөл боловсруулсан байгууллага, зохиогч хариуцах ба зураг төслийн техникийн шийдэл болон төсөвт өртгийн тооцооны талаар гаргасан дүгнэлтийн алдааг магадлал хийсэн этгээд хариуцна.**

Баян-Өлгий аймгийн Бугат сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл шинэчлэлт болон шинээр хийгдэх авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийн баримт бичгийг холбогдох нормуудын шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн бөгөөд уг зураг төслөөр зам барилгын ажил гүйцэтгэх боломжтой гэж дүгнэж байна.

Тус зураг төслийн баримт бичигт “Зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааг зохион байгуулах журам”-ын дагуу магадлалын ерөнхий дүгнэлт бичсэн болно.

Магадлалын ерөнхий дүгнэлт нь орон тооны бус экспертүүдийн гаргасан дүгнэлтийн хамт хүчинтэй. (Хавсралт: 5 хуудас)

“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ — Х.ПҮРЭВЖАРГАЛ

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛ, СТАНДАРТ, НОРМ, НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН ДАРГА — Д.БАЗАРСАД

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛ, СТАНДАРТ, НОРМ НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН — Э.ЭНХТӨГС

# МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

**ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР, МАРК, ХУУДАСНЫ ТОО.**

*Авто зам, замын байгууламжийн зураг төсөл* 2021 оны 12 сарын 07 өдөр

| Д/Д | Утга | Тайлбар |
|---|---|---|
| 1 | **Объектын нэр** | Баян-Өлгий аймгийн Бугат сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл шинэчлэлт болон шинээр хийгдэх авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл |
| 2 | **Объектын байршил, хүчин чадал** | Баян-Өлгий аймгийн Бугат сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл шинэчлэлт болон шинээр хийгдэх 5,817км авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл |
| 3 | **Зураг төслийн байгууллага** | “КАДСҮРВЭЙ” ХХК |
| **3. Дүгнэлтийн товч утга:** ***/Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 168 дугаар тушаалын 9-р зүйл/*** | | |
| 4 | **9.9.1. авто зам, замын байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, ажлын даалгавар, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал;** | *Баян-Өлгий аймгийн Бугат сумын төвд 7,9км хатуу хучилттай авто замын өргөтгөл шинэчлэлт болон шинээр баригдах авто замын зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт боловсруулж Бугат сумын Засаг дарга А.Жамбал баталсан байна.*<br>*Зураг төслийг Бугат сумын Засаг дарга А.Жамбалтай зөвшилцөж баталгаажуулсан байна.* |
| 5 | **9.9.2. инженерийн шийдэл, бүтээц нь дагаж мөрдөж байгаа норм дүрэм, стандарт, инженер-геологийн дүгнэлт, техникийн нөхцлийн дагуу зохиогдсон эсэх;** | *Инженер-геологийн судалгааны дүгнэлтийг “ИНЖГЕОТЕХ” ХХК-д боловсруулсан. Зам нь газар хөдлөлтийн 8 баллын бүсэд хамрагдана.* |
| 6 | **9.9.3. чиглэл, байршил, төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон хувилбарын талаарх дүгнэлт;** | *Сумын төвийн доторх авто замын өргөтгөл шинэчлэлт болон шинээр хийгдэх замын ажлын зураг төсөл тул хувилбарын сонголт шаардлагагүй.* |
| 7 | **9.9.4. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны норм нормативын баримт бичгийн шаардлагыг баримталсан байдал;** | *Тухайн зураг төслийн захиалгаар хийгдэх ажлын бүрэлдэхүүнд тусгагдаагүй.* |
| 8 | **9.9.5.магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийн шаардлагыг үндэслэн техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэлийн судалгаа, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана.** | *Ерөнхий төлөвлөгөө болон зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын хүрээнд холбогдох Норм дүрмийн шаардлагад нийцүүлэн төслийг боловсруулсан байна.* |
| 9 | **9.11.1. авто зам, замын байгууламжийн сонгосон байршил, техник-эдийн засгийн үзүүлэлтүүд, зураг төслийн үндсэн төлөвлөлт, техникийн шийдэл, бүтээцийн талаар тусгасан товч тодорхойлолт;** | *Тухайн зураг төслийн захиалгаар хийгдэх ажлын бүрэлдэхүүнд тусгагдаагүй.*<br>*Харин зураг төслийн үндэслэл, үндсэн төлөвлөлт болон техникийн шийдлийн талаар “Тайлбар бичиг”-т тодорхой дурьдсан байна.* |
| 10 | **9.11.2.зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдэл нь материал, түлш, эрчим хүч, усны нөөцийг хэмнэлттэй ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байдал:** | *Материалын болон төсөвт өртгийн хэмнэлтийг анхаарч замын зургийг боловсруулсан байна.* |
| 11 | **9.11.3. эдийн засгийн үр ашиг, хөдөлгөөний аюулгүй байдал, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн ажиллагаа, байгууламжийн нийгмийн ач холбогдол, барилгын ажлын төсөвт өртгийн тооцооны талаарх дүгнэлт гэх мэт.** | *Тухайн зураг төслийн захиалгаар хийгдэх ажлын бүрэлдэхүүнд тусгагдсан зүйлс тухайлбал Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зам, замын гарцад тэмдэг, тэмдэглэгээг тусгаж өгсөн байна.* |

**Дүгнэлт бичсэн:** *У.ПҮРЭВЖАВ*

**Эксперт №** **/овог, нэр /** **/гарын үсэг/**

MONGOLIA PUREVJAV USH CONSULTING ENGINEER ЗЗИ-01-11

*2021 оны 12 сарын 07-ны өдөр*

*Зураг төслийн баримт бичгийн*

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР /ТӨСВИЙН ТООЦОО/

| д/д | Утга | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Объектийн байршил, хүчин чадал | Баян-Өлгий аймаг, Бугат сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл шинэчлэлт болон шинээр хийгдэх 5.817 км авто замын барилгын ажил.<br>Замын урт-5.817 км. |
| 2 | Объектийн нэр, шифр | Баян-Өлгий аймаг, Бугат сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл шинэчлэлт болон шинээр хийгдэх 5.817 км авто замын барилгын ажлын хяналтын төсөв.<br>Шифр № КС66/21 |
| 3 | Объектийн бүрдлийн хэсгийн нэр, хуудасны тоо, гүйцэтгэсэн ААН байгуулага | Баян-Өлгий аймаг, Бугат сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл шинэчлэлт болон шинээр хийгдэх 5.817 км авто замын барилгын ажлын хяналтын төсөв-1 дэвтэр.<br>Зураг төслийн байгууллага "Кад Сүрвэй" ХХК |
| 4 | Төсвийн тооцооны программ, төсвийн тооцоог хийсэн байгууллагын нэр, гүйцэтгэсэн инженер | Зам, Тээврийн Хөгжлийн сайдын 2019 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 256 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм" ЗЗБНбД 81-013-2019, 2 дугаар хавсралтаар баталсан "Зам, замын байгууламжийн төсөв бодоход хэрэглэх ажилчдын цагийн тарифт цалингийн жишиг", 3 дугаар хавсралтаар баталсан "Авто зам, замын байгууламжийн машин ашиглалтын нэг машин цагийн үнэ", 4 дүгээр хавсралтаар баталсан "Автомашинаар ачаа тээвэрлэх 1 тн.км-ийн жишиг тариф"-ыг ашиглан төсөв зохиох компьютерийн RBC-Estimator" программ ашиглан төсвийн тооцоог хийсэн байна.<br>Баян-Өлгий аймаг, Бугат сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл шинэчлэлт болон шинээр хийгдэх 5.817 км авто замын барилгын ажлын хяналтын төсвийг /5 808 705 579 төгрөг/ "Кад Сүрвэй" ХХК, мэргэшсэн төсөвчин Б.Мөнгөншагай хийж гүйцэтгэсэн байна. |
| 5 | Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын тоо хэмжээг үнэн зөв тодорхойлсон байдал | Зургийн инженерийн тодорхойлсон ажлын тоо хэмжээг төсвийн тооцоонд хавсаргасан байна. |
| 6 | Төсвийн тооцоонд ашигласан норм, норматив, үнэ үнэлгээ | Төсвийн тооцоог БНбД 81-25-07, БНбД 81-26-08, БНбД 81-28-07 суурь жишиг нормоор үнэлсэн байна. |
| 7 | Төсвийн тооцооны арга, аргачлалын оновчтой байдал, төслөөр тодорхойлсон нөөцийг оновчтой ашигласан байдал | Төсвийн тооцооны иж бүрдэл хангагдсан байна. |
| 8 | Төсвийн тооцоо, түүний хэлбэржүүлэлтэд зайлшгүй оруулах шаардлагатай засвар, өөрчлөлт | Төсвийн тооцоонд дараах өөрчлөлтийг оруулж, дахин хянуулах шаардлагатай. Үүнд:<br>- Материалын зардлын тооцоонд бүх материалын үнийг дахин хянаж тухайн бүс нутгийн дундаж үнээр НӨАТ-гүй дүнгээр тооцож төсвийг хийх<br>- Даланд тохирох материал, элс хайрган хольц гэх мэт карьераас ашиглах материалыг 15 км-ээс, |

| | | |
|---|---|---|
| | | ф1000 мм хоолой, авто зам, явган замын хашлага гэх мэт орон нутагт үйлдвэрлэх, худалдан авах боломжтой материалыг 400 км-ээс тээвэрлэхээр тооцсон байна. Тээврийн зайг яаж тооцсон талаарх тайлбарыг ирүүлэх<br>- Төсөвт голлох материалын тээврийн зайг хүснэгтээр гаргаж зургийн байгууллагаар баталгаажуулах /ямар материалыг хаанаас тээвэрлэхээр тооцсон талаар/<br>- Элс хайрган хольц, Зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй элс хайрганы хольц, даланд тохирох материалыг 1 ижил үнээр тооцож төсөвт тусгах<br>- Термопластик будаг /гэрэл ойлгоч, цавуу хамт/ ажлын материалын орцыг төсвийн нормын дагуу тооцох<br>- Явган хүний замын хучилтыг өнгөт хавтангаар хийх ажилд ажлын зурагт тусгагдсаны дагуу элс, элс цементэн хольц тооцох<br>- Зогсоолын хашлага тавих ажилд дугуйн замын хашлага тооцсон байна. Дахин хянаж шалгах<br>- Даланд тохирох материал, элс хайрган хольцыг 15 км-ээс, тохиромжгүй материал, ургамлын хөрсийг 5км-ээс тээвэрлэхээр тооцсон байна. Дахин хянаж шалгах<br>- Нүүлгэн шилжүүлэх зардлын тооцоог буруу хийсэн байна. Дахин хянаж шалгах<br>- Төмөрбетон хоолойн барилга ф 1.0 м ажилд арматурын орцыг дахин хянаж ажлын зургийн дагуу тооцох<br>- ИШС-ний худаг, гадаргуун ус зайлуулах лоток байрлуулах ажлын материалын орц, нэгж үнийг дахин хянаж зах зээлийн жишиг үнийн дагуу НӨАТ-гүй дүнгээр тооцох<br>- Ажлын тоо хэмжээг зургийн экспертээр хянуулж батлуулан төсөвт хавсаргах.<br>- Асфальтбетон заводыг угсарч байрлуулах зардлыг тооцсон боловч асфальт тээвэрлэх зайг 18 км -ээр тооцсон байна. Тайлбарыг ирүүлэх.<br>- Үйлдвэр заводыг нүүлгэх зардлыг төсөвт тооцох эсэх. |
| | *Дүгнэлтийн товч утга* | |
| 1 | Төсвийн тооцоо нь дагаж мөрдөж буй норм, дүрэм, стандартын дагуу оновчтой зохиогдсон эсэх | Дүгнэлтээр тодорхойлсон алдааг залруулсаны дараа төсвийн тооцоог хянаж, баталгаажуулах боломжтой. |

Дүгнэлт бичсэн:

Эксперт №12-03 Л.Баасанбат

МОНГОЛ УЛС Лувсансамдантийн БААСАНБАТ ТЭРГҮҮЛЭХ ТӨСӨВЧИН

2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр

Эксперт дүгнэлтийг компьютерээр 2 хувь бичиж, гарын үсэг, тамга тэмдгээ дарж баталгаажуулсан байна.

*Зураг төслийн баримт бичгийн*

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР /ТӨСВИЙН ТООЦОО/

| д/д | Утга | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Объектийн байршил, хүчин чадал | Баян-Өлгий аймаг, Бугат сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл шинэчлэлт болон шинээр хийгдэх 5.817 км авто замын барилгын ажил.<br>Замын урт-5.817 км. |
| 2 | Объектийн нэр, шифр | Баян-Өлгий аймаг, Бугат сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл шинэчлэлт болон шинээр хийгдэх 5.817 км авто замын барилгын ажлын хяналтын төсөв.<br>Шифр № КС66/21 |
| 3 | Объектийн бүрдлийн хэсгийн нэр, хуудасны тоо, гүйцэтгэсэн ААН байгуулага | Баян-Өлгий аймаг, Бугат сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл шинэчлэлт болон шинээр хийгдэх 5.817 км авто замын барилгын ажлын хяналтын төсөв-1 дэвтэр.<br>Зураг төслийн байгууллага “Кад Сүрвэй” ХХК |
| | | |
| *№* | *Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил* | *Алдаа зөрчлийг засаж, төсөлд засвар оруулсан тухай тайлбар, танилцуулга* |
| *1* | Материалын зардлын тооцоонд бүх материалын үнийг дахин хянаж тухайн бүс нутгийн дундаж үнээр НӨАТ-гүй дүнгээр тооцож төсвийг хийх | Материалын зардлыг одоо байгаа зах зээлийн ханшийг дахин судлан үзэж НӨАТ-гүй дүнгээр төсөвт тооцов. |
| *2* | Даланд тохирох материал, элс хайрган хольц гэх мэт карьераас ашиглах материалыг 15 км-ээс, ф1000 мм хоолой, авто зам, явган замын хашлага гэх мэт орон нутагт үйлдвэрлэх, худалдан авах боломжтой материалыг 400 км-ээс тээвэрлэхээр тооцсон байна.<br>Тээврийн зайг яаж тооцсон талаарх тайлбарыг ирүүлэх | Тухайн орон нутагт судалгаа явуулж Даланд тохирох материал, элс хайрган хольц гэх мэт карьераас ашиглах материалыг 12 км-ээс, ф1000 мм хоолойг 400км буюу Ярантын боомтоос, авто зам, явган замын хашлагыг аймгийн төвөөс 8км-ээс, авахаар тооцож төсвийг дахин засварлав. |
| *3* | Төсөвт голлох материалын тээврийн зайг хүснэгтээр гаргаж зургийн байгууллагаар баталгаажуулах /ямар материалыг хаанаас тээвэрлэхээр тооцсон талаар/ | Төсөвт голлох материалын тээврийн зайг хүснэгтээр гаргаж зургийн байгууллагаар баталгаажуулан төсөвт хавсаргав. |
| *4* | Элс хайрган хольц, Зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй элс хайрганы хольц, даланд тохирох материалыг 1 ижил үнээр тооцож төсөвт тусгах | Элс хайрган хольц, Зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй элс хайрганы хольц, даланд тохирох материалыг 1 ижил үнээр буюу 2000 төгрөгөөр тооцож төсвийг дахин засварлав. |
| *5* | Термопластик будаг /гэрэл ойлгоч, цавуу хамт/ ажлын материалын орцыг төсвийн нормын дагуу тооцох | Термопластик будаг /гэрэл ойлгоч, цавуу хамт/ ажлын материалын орцыг дахин шалгаж төсвийн нормын дагуу тооцов. |
| *6* | Явган хүний замын хучилтыг өнгөт хавтангаар хийх ажилд ажлын зурагт тусгагдсаны дагуу элс, элс цементэн хольц тооцох | Явган хүний замын хучилтыг өнгөт хавтангаар хийх ажилд элс, элс цементэн хольц нэмж тооцов. |

| | | |
|---|---|---|
| 7 | Зогсоолын хашлага тавих ажилд дугуйн замын хашлага тооцсон байна. Дахин хянаж шалгах | Зогсоолын хашлага тавих ажилд дугуйн замын хашлага тооцсоныг дахин хянаж авто замын хашлага болгон засварлав. |
| 8 | Даланд тохирох материал, элс хайрган хольцыг 15 км-ээс, тохиромжгүй материал, ургамлын хөрсийг 5км-ээс тээвэрлэхээр тооцсон байна. Дахин хянаж шалгах | Даланд тохирох материал, элс хайрган хольцыг 12 км-ээс, тохиромжгүй материал, ургамлын хөрсийг 5км-т байрлах хогийн цэгрүү тээвэрлэхээр тооцсон. |
| 9 | Нүүлгэн шилжүүлэх зардлын тооцоог буруу хийсэн байна. Дахин хянаж шалгах | Нүүлгэн шилжүүлэх зардлын тооцоог дахин хянаж төсвийг засварлав. |
| 10 | Төмөрбетон хоолойн барилга ф 1.0 м ажилд арматурын орцыг дахин хянаж ажлын зургийн дагуу тооцох | Төмөрбетон хоолойн барилга ф 1.0 м ажилд арматурын орцыг дахин хянаж төсвийг засварлав. |
| 11 | ИШС-ний худаг, гадаргуун ус зайлуулах лоток байрлуулах ажлын материалын орц, нэгж үнийг дахин хянаж зах зээлийн жишиг үнийн дагуу НӨАТ-гүй дүнгээр тооцох | ИШС-ний худаг, гадаргуун ус зайлуулах лоток байрлуулах ажлын материалын орц, нэгж үнийг дахин хянаж зах зээлийн жишиг үнийн дагуу НӨАТ-гүй дүнгээр тооцов. |
| 12 | Ажлын тоо хэмжээг зургийн экспертээр хянуулж батлуулан төсөвт хавсаргах. | Ажлын тоо хэмжээг баталгаажуулан төсөвт хавсаргав. |
| 13 | Асфальтбетон заводыг угсарч байрлуулах зардлыг тооцсон боловч асфальт тээвэрлэх зайг 18 км -ээр тооцсон байна. Тайлбарыг ирүүлэх. | Асфальтбетон заводыг угсарч байрлуулан 8км – ээс тээвэрлэхээр тооцов. |
| 14 | Үйлдвэр заводыг нүүлгэх зардлыг төсөвт тооцох эсэх. | Үйлдвэр заводыг нүүлгэх зардлыг төсөвт нэмж тооцон төсвийг дахин засварлав. |

Дүгнэлт бичиж,биелэлтийг шалгасан: Тэргүүлэх төсөвчин

эксперт № 12-03 Л.БААСАНБАТ

2022 оны 04 дүгээр сарын 21-ны өдөр

Биелэлтийн тайлбар бичсэн: Мэргэшсэн төсөвчин

Б.МӨНГӨНШАГАЙ

2022 оны 04 дүгээр сарын 21-ны өдөр